

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр

№ 24/37

Улаанбаатар хот

Хаалттай хүрээнд өрийн хэрэгсэл гаргах тухай

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.4 дэх заалт Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 24/05 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн 2024 оны эх үүсвэрийн төлөвлөгөө”, Компанийн ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор нийт 6,000,000,000 (зургаан тэрбум) төгрөг хүртэл үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл (цаашид “Өрийн хэрэгсэл”)-ийг гаргаж санхүүжилт татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Компанийн гаргаж буй Өрийн хэрэгслийг “Монгол Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо ӨЗБ” ГҮТББ-ын зохицуулалтад байх Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлж хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгон арилжаалсугай.
3. Өрийн хэрэгслийг мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эрэлт хэрэгцээ, зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан анхдагч зах зээлд хэсэгчлэн (транч) гаргах нөхцөл, хувь хэмжээг энэхүү тогтоолын Хавсралтад зааснаар баталсугай.
4. Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлд Өрийн хэрэгслийг бүртгүүлэх, анхдагч зах зээлд арилжаалахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагаар “Таван Богд Капитал ҮЦК” ХХК-ийг сонгосугай.
5. “Таван Богд Капитал ҮЦК” ХХК-тай “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулах, тус гэрээний дагуу хүлээх мөнгөн хөрөнгийн гүйлгээ, зарцуулалтыг “Таван Богд Капитал ҮЦК” ХХК-ийн бүрэн хяналтад байлгах үүргээ биелүүлэх зорилгоор бусад шаардлагатай гэж үзсэн гэрээг тус компанитай байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
6. Өрийн хэрэгсэл гарган арилжаалах замаар татан төвлөрүүлэх санхүүжилтийн үүргийн гүйцэтгэл хангуулагчаар “Таван Богд Капитал ҮЦК” ХХК ажиллахыг дурдсугай.
7. Өрийн хэрэгсэл гарган санхүүжилт татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж холбогдох баримт бичиг, бусад шаардлагатай гэрээ, хэлцэлд Компанийг төлөөлөн гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

“ЛЭНДМН БЭСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр

№ 24/37

Улаанбаатар хот

8. Өрийн хэрэгсэл гарган санхүүжилт татан төвлөрүүлэх ажилтай холбогдон гарах аливаа төлбөр, шимтгэл, хураамж, бусад зардлыг холбогдох гэрээ, хууль тогтоомжид заагдсан хугацааны дотор тухай бүр төлөх, Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулан ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
9. Өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой ажлын үйл явц, үр дүн болон энэхүү тогтоолын хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тухай бүр танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

